

## ӨРХҮҮДИЙН ЯДУУРАХ ЭМЗЭГ БАЙДЛЫН СУДАЛГАА

**Удирдагч:** Б. СУВД, доктор, профессор, МУИС-ийн ЭЗС-ийн Захирал  
**Судлаачид :** Б. АЛТАНЦЭЦЭГ, Б. ОТГОНТӨГС, Х.ЦЭВЭЛМАА,  
Б.ЛХАГВАСҮРЭН, Т.ОЮУНБААТАР, С. ДӨЛБАДРАХ,  
Б.СОЁЛМАА, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын  
тэнхмийн багш, Н. ДООСМАА, Эдийн засгийн онолын  
тэнхмийн ажилтан

*Сүүлийн жилүүдэд ард түмний амьдралын түвшин доройтож, ядуурлын хэмжээ улам бүр нэмэгдэж байгаа нь улс орны хэмжээний хурцадмал асуудал болоод байна. Засгийн Газраас ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөр, төсөл, судалгаа хийж байгаа нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгсөөр байна. Гэвч сүүлийн жилүүдэд ядуурал буурсангүй харин нэмэгдэж, ужгирсан ядуурал буюу үе дамжин ядуурах хандлага бий болж байна. Манай орны хувьд ядуурлын тухай бодлого нь ихэвчлэн ядуу өрх, ядуу хүмүүст чиглэгдэж байсан бөгөөд энэхүү байдал нь цаг хугацааны хувьд шалгагдаж ядуурлыг өөр байдлаас харахыг сануулж байна. Өөрөөр хэлбэл, ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлого харьцангуй бага байгаа нь зарим талаараа ядуурлыг нэмэгдүүлэх, ядуу болж нийгмийн баялгийг хүртэх гэсэн бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож байна. Олон улсын тодорхойлолтоор бол ядуурал нь зөвхөн эдийн засгийн асуудал биш бөгөөд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээний олон хүчин зүйлээр тодорхойлогдож байдаг.*

*Байгалийн гамшиг ган, зуд, эдийн засгийн доройтол, өвчин эмгэг зэрэг олон эрсдэлүүд ядуурах эмзэг байдлыг бий болгодог. Сүүлийн жилүүдэд үргэлжилсэн ган, зудад нэрвэгдсэн олон хүн ардууд ядууралд орж, улмаар дорвитой арга хэмжээ авахгүй бол энэ хандлага улам бүр өсөх хандлагатай болж байна.*

*Энэхүү ажилд тусгагдсан эмзэг байдлын тухай ойлголт, ухагдахуун, арга зүй нь ядуурлыг бууруулах төрийн бодлогод бас нэгэн шинэ боломжийг олгож байна. Ядуурах эмзэг байдлын судалгааг олон улсын хэмжээнд өргөн ашиглаж байгаа бөгөөд энэхүү ажил олон улсын хэмжээний судалгаануудтай харьцуулан шинэлэг арга зүйгээр судалснаараа чухал ач холбогдолтой юм*

## ОРШИЛ

1990 оноос Монгол улс зах зээлийн тогтолцоонд шилжих болсон нь ард түмний амьжиргааны өртөгт мэдэгдэхүйц өөрчлөлтийг бий болгосон. Ядуурлын түвшин нэмэгдэж, цалин хөлсний хэмжээ эрс унахын зэрэгцээ ажилгүйдэл нийгмийн томоохон асуудал болон гарч ирж, олон нийтийн зориулалт бүхий төсөв, зардлыг бууруулснаар эрүүл мэнд, боловсролын салбарын чанарт сөргөөр нөлөөлсөн байна. Сургууль завсардах болон сургуульд үл хамрагдагчдын тоо өсөн нэмэгдэж, гудамжны хүүхэд олширч, гэмт хэрэг ихэссэнээр нийгмийн бухимдал бий болсон юм. /НҮБ Хөгжлийн

хөтөлбөр 1997 он/. Ийнхүү Монгол улсад ядуурал бодит үзэгдэл болсныг гадаад дотоодын байгууллага, эрдэмтэд, судлаачид олон талаас нь судалж, өөрсдийн дүгнэлт, санал, зөвлөмжийг өгсөн юм.

Монгол Улсын Засгийн Газраас 1994 онд Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийг боловсруулж, улсын хэмжээнд хот, аймаг, сум, багийн түвшинд хэрэгжүүлж ирэв. Түүнчлэн ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байгаа нь ядуурлыг бууруулах бодлого засгийн газрын анхаарлын төвд ямагт байдгийн нэг илэрхийлэл юм.

1995 онд Дэлхийн Банкнаас “Монгол: шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ” судалгааг явуулан үнэлгээ дүгнэлт хийж, зөвлөмж гаргасан нь нилээд иж бүрэн, өргөн хүрээтэй судалгаа болсон бөгөөд Монгол дахь ядуурлын байдалд хийсэн анхны судалгаа болсон юм. Энэ судалгаагаар ядуурлын дүр төрхийг эдийн засаг, нийгмийн байдлын хувьд тодорхойлж, ядуучуудад зориулан төр засгаас явуулж байгаа арга хэмжээний үр дүн, цаашид ядуурлыг бууруулах бодлого, хэрэгжүүлэх хөтөлбөрийн үндсэн чиглэлийг авч үзжээ.

1998 онд Монголын Улсын Үндэсний Статистикийн Газраас эрхлэн “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” хийсэн нь хүн амын амьжиргаа, ядуурлын талаар бие дааж хийсэн томоохон судалгаа болсон юм. Энэ судалгаагаар ядуу хүн амын амьдралын дүр төрх, ядуурлын тархалт, гүнзгийрэлт, үндсэн шинж нөлөөллийг тодорхойлсон.

2001 онд Монгол Улсын Засгийн Газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн стратегид тэгш байдал ядуурлыг бууруулах асуудлыг тусгах” судалгааг хийж, Монгол Улсын Засгийн Газраас ядуурлыг бууруулах талаар явуулж байгаа бодлого, ядуурлын макро эдийн засгийн асуудлууд, үндэсний хөгжлийн стратеги, зээл тусламжийн асуудлуудыг авч үзжээ.

Ядуурлын талаар хийгдсэн судалгаануудын үр дүнгээс үзвэл Монгол дахь ядуурлын хүрээ, цар хэмжээ, орлогын ядуурлын хувьд төдийлөн нэмэгдээгүй. Харин ядуурлын гүнзгийрэлт нэмэгдэж, ядуурлын туйлдал өссөн байна. Түүнчлэн ядуурлыг зөвхөн орлогын талаас нь голчлон тодорхойлж байгаагаас хамаарч, ядуурлын хэмжээ хүн амын 36 орчим хувиас хэтрээгүй дүн гарч байна. Гэтэл ядуурал нь дан ганц орлогоор тодорхойлогдохгүй бөгөөд чадавхийн болон нийгмийн доройтлын ядуурлыг ядуурлын хэмжээнд оруулж тооцвол хүн амын 70 орчим хувь нь ядууд тооцогдохоор байна.

Үүнээс гадна Монгол Улсын Засгийн Газраас ядуурлыг бууруулах талаар авч явуулж байгаа бодлогын гол хэсэг нь ядуу өрхүүдийг ядуурлаас гаргахад чиглэгдэж, ядуурахаас нь өмнө урьдчилан сэргийлэх бодлого харьцангуй бага хувьтай байна. Бидний төсөөлж байгаагаар дэлхий дахинаа ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлого давамгайлж байгаа өнөө үед ядуурч болзошгүй өрхүүдийн судалгааг улсын хэмжээнд хийж, түүний үр дүнг ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлогын үндэс болгон хэрэглэх шаардлагатай болжээ.

Энэ зорилгын үүднээс бид ядуурч болзошгүй өрхүүдийн тандах судалгааг явуулж, өрхүүдийн эмзэг байдлыг тодорхойлох судалгааны арга зүйг тодорхойлох зорилго тавьж, энэхүү тандах судалгааг хийлээ.

Бидний хийсэн өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгаа нь манайд урьд өмнө хийгдэж байсан судалгаануудаас ялгаатай бөгөөд бид өрхүүдийн ядуурах эмзэг байдлыг судалгаанд хамрагдсан өрх бүрээр тодорхойлохыг зорьсон юм.

Ийм судалгааг хийснээр Монголын өрхүүдийн эмзэг байдал, эрсдэлийг бусад орнуудынхтай жиших, харьцуулах боломжтойн зэрэгцээ аймаг, орон нутгуудыг өөр хооронд нь харьцуулж үзэх, тэдэнд тохирсон ялгаатай бодлогуудыг явуулах боломжтой болох юм.

## **1. ЯДУУРАЛ БА ЭМЗЭГ БАЙДАЛ**

### **1.1 Ядуурал ба эмзэг байдал: нийтлэг ба ялгаатай тал**

Өнөөдрийн ядуу нь маргааш ядуу биш болж, өнөөдөр ядуу биш байгаа хүн маргааш ядуу болж, шинээр ядуугийн эгнээнд багтаж болох юм. Тэгэхээр ядуурал нь стохастик шинжтэй болж байна. Ядуурлын талаарх ойлголт, тодорхойлолт, тайлбарууд одоо хүртэл судлаачдын дунд судалгааны гол чиглэл болдог. Ядуурлын мөн чанар, шалтгаан глобалчлагдаж буй дэлхийд өөрчлөгдөж байгаа учир ядуурлын уламжлалт тайлбараас гадна ядуурлыг тайлбарлах шинэ хэлбэр бий болж байна.

Ядуурлыг өргөн хүрээнд авч үзвэл: хувь хүн, хүн амын нэг хэсэг нь нийгмийн хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн наад захын хэмжээнд хэрэглээгээ хангаж чадахгүй буюу тэр хэмжээнд бүрэн хооллож, хувцаслаж, орон гэртэй байж, эрүүл мэнд, боловсролын болон бусад үйлчилгээгээр хангагдаж чадахгүй бол түүнийг ядуу гэнэ (П.Таунсенд).

Орлогын ядуурал хөгжиж буй орнуудад нийтлэг ажиглагдахын зэрэгцээ цаг хугацаанаас хамаарч ужгирсан ядуурлын онцлогийг тодорхойлж байна. Ямар ч үед орлогын ядуурал нь зөвхөн дундаж орлого ядуурлын шугамнаас доогуур болсны улмаас зайлшгүй архаг ядуу болох биш, харин ядуурал өөрөө олон талтай бас тэгээд дундаж орлого ядуурлын шугамнаас доогуур байгаа тул архаг ядуурал тохиолдож байгаа болно. (David Hulme, Andrew Shepherd and Karen Moore, CPRC) Тиймээс архаг ядуурал нь хоёр гол хандлагатай байна. Үүний нэг нь, баялгийн нэг статус нөгөө статусаар солигдож, түр зуурын ядууралд орох, нөгөө нь баялгийн түр зуурын болон байнгын өөрчлөлтийг үнэлэн ядууралд орж байгааг тодорхойлох явдал юм. Эхнийхээр бол архаг ядуу байгаа хүнийг ялгаж байна, харин дараагийнхаар бол хүмүүсийн архаг ядуурлыг түр зуурын ядуурлаас ялгаж байна. Иймд ядуу хүмүүсийн дундаж орлого удаан хугацаанд ядуурлын шугамнаас доош орж, тухайн хүн архаг ядууралд орж байна уу, аль эсвэл ядуу хүмүүсийн дундаж орлого удаан хугацаагаар үргэлжлэн ядуурлын шугамнаас доош орж, тухайн хүн архаг ядууралд орж байна уу гэдгийг зааглах хэрэгтэй болно.

Нөгөө талаар ужгирсан ядуурал нь үе дамжсан (inter-generationally transmitted. IGT) ядуурлын шинж чанартай болж байгаа тул ядуурлыг хүмүүний, нийгэм-соёлын, нийгэм-улс төрийн, санхүү/материалын, хүрээлэн буй орчин/байгалийн үзүүлэлтүүдээс хамааруулан ангилж, ядуурлын түвшин хэр зэрэг байгаа болон, харьцангуйгаар бууруулахад ямар бэрхшээл тулгарч буйг зохистойгоор тодорхойлохыг зорьж байна. Улмаар ядуурал ба ужгирсан ядуурлын хоорондын ялгааг зааглахаас гадна ужгирсан ядуурлын шинж чанар ба шалтгааныг нарийвчлахгүй бол ядуурлыг бууруулахыг зорьж буй одоогийн хүчин чармайлтыг үгүйсгэж болох талтай.

Иймд хөгжиж буй орнуудад хийгдэж буй ядуурлын талаарх судалгаанд хүн амыг хэд хэдэн хэсэгт хувааж үзэж байна. Тухайлбал, үргэлжийн ядуу (үе бүхэнд өрхийн зардал ядуурлын шугамнаас доош орох), архаг ядуу (бүхий л үеийн өрхийн дундаж зардал ядуурлын шугамнаас доош орох, гэхдээ үе бүрт ядуу биш), түр зуурын ядуу (бүхий л үеийн өрхийн дундаж зардал ядуурлын шугамнаас дээш, гэхдээ ядуурал ямар нэгэн хэлбэрээр тохиолдоно), хэзээ ч ядуу биш гэж өрхүүдийг ангилсан байна. (Jalan and Ravallion, 2000) Архаг ядуурал руу өртөмтгий хэсгүүдийг өрхүүдийн судалгаанд үндэслэн шинжилж байна.

Ядууралтай харьцуулж үзвэл эмзэг байдал бол олон талтай, зөвхөн эдийн засгийн шокуудтай холбоотой биш, мөн түүнчлэн экологийн байдал, байгалийн аюул гамшиг юмуу хүний үйл ажиллагаагаар хохирол учрах гэх зэрэг үйл явдалтай холбоотой. (Third Asia Development Forum. 2001) Эмзэг байдал нь ядуурлын динамикийг ойлгоход бидэнд тусалдаг.

Хүн ам, өрхүүд, хувь хүмүүст янз бүрийн эрсдэл учирч, тэдгээрийг ядуурал руу түлхэж болно. Тиймээс нийгэм тэдгээрийн эмзэг байдлыг бууруулахын тулд, мөн ямар нэгэн шок гарснаас бий болох нөлөөллийг шийдэхийн тулд зохих алхмуудыг авч хэрэгжүүлэх болно. Эмзэг байдал нь хувь хүн болон өрхийн сайн сайхан байдал хамгийн бага хэрэглээний түвшнээс доогуур болж байгааг харуулна.

Эмзэг байдлыг эрсдэлээр тодорхойлно. Эрсдэл нь байгалийн аюул гамшиг, иргэний зөрчилдөөн, эдийн засгийн байдал муудах гэх зэрэг макро эдийн засгийн эрсдэлүүд байхаас гадна ургац алдах, ажилгүй болох, өвчин эмгэг тусах, аваар осол, золгүй явдал тохиолдох, хөдөлмөрийн чадваргүй болох, өндөр настай болох гэх зэрэг өрхөд нүүрлэж болох эрсдэлүүд байна. Тиймээс эмзэг байдал бол динамик ойлголт, энэ нь орлого болон хэрэглээний өөрчлөлт, аль эсвэл сайн сайхан байдалд нөлөөлөх бусад өөрчлөлтүүд, тухайлбал, эрүүл мэнд, орон гэртэй болох гэх мэт өөрчлөлтүүдийг хэмжихэд төвлөрч байдаг.

Дийлэнх судалгаанд эрсдэлийн өөрчлөлтийг орлого ба хэрэглээний вариацийн өөрчлөлт, стандарт хазайлтаар хэмждэг.

Эмзэг байдлыг үнэлэх нь нэг цаг хугацаан дахь ядуурлыг хэмжихээс нилээд төвөгтэй. Тэгээд ч эмзэг байдлыг хэмжихэд өрхийн хөрөнгийн (биет, хүмүүний, санхүүгийн) тоон мэдээлэл, өрхийн боломжийг тодорхойлох эдийн засгийн бодлого шаардлагатай. Гэтэл өрхүүдийн талаарх өнөөдрийн түүвэр судалгаа нь хэрэгцээтэй мэдээлэлээр хангаж чадахгүй байгаа юм. Тиймээс

өрхийн судалгааг өргөжүүлэхээс гадна оролцооны аргын судалгааг өргөн хэрэглэж байна.

Эмзэг байдал нь хүн бүрт нөлөөлж болно. Энгийн албан хаагч боломжийн цалин авдаг, гэхдээ ажлаа алдвал эмзэг болж, ядуурал руу орно. Эмзэг байдал нь ядуу хүний хувьд болон одоогоор ядуурлын шугамнаас дээгүүр байгаа хүний хувьд санаа зовоосон ойлголт, яагаад гэвэл орлого л буурвал тэднийг ядуу зүдүү байдал руу түлхэх болно. Эцэстээ ядуу хүмүүс бол эрсдэлд дургүй, өндөр эрсдэлтэй байх хүсэлгүй, тэдний хувьд өндөр орлоготой үйл ажиллагаа нь ядуурал руу оруулна.

Өөр нэгэн арга бол урт хугацааны дундаж хэрэглээ нь ядуурлын шугамнаас доогуур болсноор урт хугацааны ядуурлыг тодорхойлж, улмаар хэмжигдсэн ядуурал нь ямар хэмжээгээр түр зуурын шинжтэй байгааг асуух явдал юм. Энэ арга нь ядууралд орж байгаа болон ядуурлаас гарч байгаа шилжилтийн хугацаа ба гүнзгийрэлтийг далд байдлаар харуулна. Энэ аргыг ашиглан Энэтхэгийн өмнөд хэсгийн тосгодын ядуурал болон Хятадын ядуурлын шугамнаас доошхи ядуу хэсгийн ядуурлыг үнэлж үзэхэд бараг тал хувь нь түр зуурын ядуурлын шинжтэй байсан байна. (Ravallion.1988, Jalan and Ravallion 1997a)

Дээрх хоёр аргын аль аль нь түр зуурын ядуурал бол олон талаараа нийт ядууралд томоохон хэсгийг эзэлдэг гэдгийг хэлж өгч байна. Ерөнхийдөө бага зэргийн хөрөнгөтэй өрхийн дийлэнх нь архаг ядуу байж болзошгүй. Боловсрол нь архаг ядуурлыг бууруулна, гэхдээ түр зуурын ядууралд түүний үзүүлэх нөлөө ялгаатай байдаг. Ядуу хүмүүс өөрсдөдөө нүүрлэж буй эрсдэлийг бүрэн хэмжээгээр зохицуулж чадахгүй учраас ядуурлыг бууруулах ямар ч стратеги байсан ядуу хүмүүст учрах эрсдэлийг зөв тодорхойлж, эрсдэлийг бууруулах ба сулруулах хэрэгтэй болно.

## **1.2 Ядуурал ба ядуурах эмзэг байдлыг бууруулах бодлого**

Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад хүчтэй нөлөөлнө. Эдийн засгийн өсөлтийн шалтгаан чухам юу байна вэ, улс орнуудад эдийн засгийн өсөлтийн хувь бараг адилхан байхад яагаад ядуурлыг бууруулах түвшин их ялгаатай байна вэ гэсэн асуултууд гарч байна. Ядуу хүмүүст хүрч чадах өсөлтийн бодлого нь ядуурлыг бууруулах стратегийг боловсруулахад их чухал билээ.

1990-ээд оноос хойшхи хугацаанд хөгжиж буй орнуудад баримталж буй ядуурлыг бууруулах чиглэл, бодлого, стратеги нь Монгол Улсын шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн асуудалд тусгалаа олсон байдаг. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, өмчийн харилцаа, үнэ ба үйлдвэрлэлийн бодлогод өөрчлөлт орсон болон өмнө нь үзүүлж байсан зээл, тусламж зогссоноор улс орны эдийн засаг уналтанд орж, үйлдвэр аж ахуйн газрууд хөрөнгө, санхүүгийн бэрхшээлийн улмаас үйл ажиллагаагаа зогсоосон. Ийнхүү ажилгүйдэл бий болж, нийгмийн үйлчилгээний зардал, тэр дундаа боловсрол, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа доройтсоны улмаас ядуурал бодит үзэгдэл болсон.

Энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын Засгийн Газар НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хоёр талт болон олон талт хандивлагчдын дэмжлэгтэйгээр Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр (ЯБҮХ)-ийг боловсруулж, 1994-2000 онуудын хооронд хэрэгжүүлсэн. ЯБҮХ нь хүн амын амьдрал доройтох, хүний хөгжлийн түвшин буурах хандлагыг өөрчлөн 2000 он гэхэд ядуурлын түвшинг тодорхой хувиар бууруулах зорилт тавьжээ. Хөтөлбөрт орлогын ядуурлыг бууруулах төдийгүй нийгмийн үндсэн үйлчилгээний хангамж, хүртээмжийг сайжруулах, хүний хөгжлийн хүчин зүйлийг хөгжүүлэх талаар тусгасан байсан.

Төрөл бүрийн шалтгаанаар хөтөлбөрийн хэрэгжилт удааширч, зарим төслүүдийн хувьд сонголт буруу хийгдсэн, хяналт шалгалт сул байсан, төсөл хэрэгжүүлэх явцад урьдчилан тооцоогүй хүндрэл бэрхшээлүүд тулгарсан гэх зэрэг шалтгааны улмаас зарим төслүүд амжилт олоогүй. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд улс орны эдийн засгийн байдал хүндэрч, өсөлт хангалтгүй байснаас олон хүн ядуусын эгнээнд шинээр нэмэгдэж оров. Иймээс Засгийн Газар 2001 онд 8 сарын турш олон улсын хөгжлийн нийгэмлэг болон ОУВС-ийн мэргэжилтнүүдийн хамтаар ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийг (ЯБСЗББ) боловсруулсан юм. Ядуурлыг бууруулахын тулд өмнө хэрэгжсэн хөтөлбөрийн ололт амжилт, алдаа дутагдал, сургамжууд дээр үндэслэн дараагийн шатны “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих” хөтөлбөрийг баталсан.

Монгол Улсын Засгийн Газрын ядуурлыг бууруулах бодлогын өнөөгийн байдлыг эдийн засгийн үзүүлэлтүүд дээр үндэслэн тайлбарлахад дараах байдалтай байна.

Монгол Улсын ДНБ-ний хэмжээ 1992 онд 2,5 %-иар буурч байсан бол 1994 онд 2,3%-иар нэмэгдэж, түүнээс хойш өссөн ч 2000 оны цаг агаарын хүндрэл, шүлхий өвчний тархалт зэргээс шалтгаалан ДНБ-ний өсөлт дөнгөж 1,1%-тай байв. Харин 2001 онд эдийн засгийн хүрээнд хэрэгжсэн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, ДНБ-ний 70 гаруй хувийг үйлдвэрлэх болов. Цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүн экспортлодог, дэлхийн зах зээлээс хараат байдаг манай орны хувьд гадаад худалдааны тэнцэл 1995 онд 58,0 сая ам долларын алдагдалтай байсан. 1999-2000 оны өвөл, хавар байгаль цаг уурын хүндрэл (ган, зуд)–ээс болж нийт малын 10,4%-аар багассан нь мал аж ахуйн салбар дахь ядуурлын түвшин огцом нэмэгдэхэд нөлөөлсөн. [СЭЗЯ]

НХХЯ-аас 2001 онд явуулсан улсын ядуурлын үзлэгийн дүнгээс харахад нийт хүн амын 14.4 хувь нь бага орлоготой, 20.0% нь ядуу, 16.3% нь нэн ядуу гэжээ. Өөрөөр хэлбэл, ядуу, нэн ядуу иргэд нийт хүн амын 36.2%-ийг эзэлж байна. Хэрэв ядуурлыг хоол хүнсний /эсвэл орлогын/ хомсдол гэж үзвэл Монголын 18-аас дээш насны хүн амын 31% нь ядуу байна. Дээр нь анхан шатны сургуулиас дээшхи боловсрол, мэргэжил олох бололцооны хомсдол, цэвэр усны гачигдлыг нэмбэл Монголын насанд хүрэгчдийн 70.7% нь ядууд тооцогдоно. 1990-2000 оны хооронд нэг өрхөд ногдох малын тоо толгой 54%-аар багассан нь мал аж ахуйн салбар дахь ядуурлын түвшин огцом нэмэгдэхэд нөлөөлсөн. [Кит Гриффин]

Ядуу хүн амын хэрэглээний ялгааг илэрхийлэх хэрэглээний гүнзгийрэлтийн индекс 9,8-13,9 хувьд хүрч, ядуурлын ялгааны индекс 1995 оноос 0,8-2,9 нэгжээр өссөн байна. 1995 онд ядуурлын гүнзгийрэлт улсын

хэмжээнд 10,9; ядуурлын туйлдал 4.8 байсан бол 1998 онд энэ үзүүлэлт 11.4 ба 5.6 болж тус тус өсчээ.

Ядуурлын гүнзгийрэлт нь ядуу хүний дундаж орлого амьжиргааны доод түвшингээс хэр доош орсныг харуулдаг бол туйлдал нь ядуу хүмүүсийн орлого хуваарилалт ядуурлын хамгийн доод түвшинд хэр зэрэг байгааг харуулдаг.

Орлогын тэгш бус хуваарилалтыг илэрхийлэх Жини коэффициент 1995 онд 0,31 байсан бол 1998 онд 0,35 болж өссөн.

Монгол дахь ядуурал нь ажил эрхлэлттэй шууд холбоотой, хот суурин газрын хөдөлмөрийн насны ядуу хүн амын 27,3%-38,8% нь ажил эрхлээгүй байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажилгүйчүүдийн 60 шахам хувийг ядуучууд эзэлдэг. (Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998)

Монголын хүн амын орлогын 1/3 нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шагнал, урамшуулал, 20 гаруй хувь ХАА-н болон ХАА-н бус үйлдвэрлэлийн орлого, 30% нь өрхийн өөрийн аж ахуй, 10% нь бусдаас үнэгүй авсан хэрэглээнээс бүрдэж байна (ҮСГ). Гэхдээ энэ нь өрхийн байршлаас ихээхэн хамааралтай байдаг. Орлогын ядуурал бодитой байгаа бөгөөд амьдралын мөчлөг, эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм ба засаглалын асуудлуудаас урган Монголын өрхүүд эмзэг байдалд өртөх явдал ихэсч байна.

Ядуурал ба ядуурах эмзэг байдлыг бууруулахдаа дан ганц архаг ядуурлын асуудлыг хөндөх боломжгүй. Монгол улсад хот ба хөдөөгийн ядуурал ялгаатай байгаа болон ядуурлын байдлыг архаг ядуурал уруу оруулахгүйгээр урьдчилан сэргийлэхийн тулд ядуурлын шинж чанар, шалтгааныг илүү нарийвчлан судлахаас гадна ядуурах эмзэг байдлын шалтгааныг өрхүүдийн хувьд илүү нарийвчилж тодорхойлоод улмаар ядуурах эмзэг байдлын хэлбэр, эрсдэлийн хэмжүүрүүдийг тодорхойлох нь нэн чухал байна.

## **2. МОНГОЛЫН ӨРХҮҮДИЙН ЯДУУРАХ ЭМЗЭГ БАЙДЛЫН СУДАЛГАА**

### **2.1 Тандах судалгаа**

Хэдийгээр хөгжиж буй орнуудын ядуурлын талаарх судалгаа шинжилгээг нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдэх, бодлого боловсруулахад өргөн хэрэглэж байгаа хэдий ч өрхүүдийн ядуурах эмзэг байдлын талаарх судалгаа тэр бүр хөгжиж буй орнуудад хийгдэж байгаагүй гэж хэлж болно. Тэр тусмаа “Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгаа” нь 1995, 1998 оны “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”, 2000 оны “Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа” гэх зэрэг судалгааны ажлуудаас арай өвөрмөц шинж чанартай.

Судалгаанд УБ хотын Сонгино-Хайрхан, Хан Уул, Баянгол дүүрэг, түүнээс гадна Хэнтий, Архангай, Дорноговь аймгуудаас сум сонгож авсан. Тандах түүвэр судалгаанд нийслэл, аймаг, сум дүүргүүдээс өрхүүдийг сонгож, улмаар өрхийн ядуурах эмзэг байдлыг тандахдаа 28 асуулттай анкетийн асуулгыг боловсруулж, улмаар асуулгын дагуу тоо, мэдээллийг цуглуулсан

юм. Энэхүү анкетийн асуулгын эхний асуултууд нь өрхийн хүн ам зүйн шинж чанаруудыг харуулах үзүүлэлтүүдийг тодорхойлоход чиглэсэн.

Тандах түүвэр судалгааны өгөгдлүүд дээр үндэслэн өрх бүрийн ядуурах эмзэг байдал болон нийт судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд ядуурах эмзэг байдал ямар байгаа судалгааны аргачлалыг боловсруулсан болно.

## **2.2 Өрхийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ**

Шилжилтийн эхний жилүүдэд ядуурал нь зөвхөн орлого буурсантай холбоотой байсан бол сүүлийн жилүүдэд үе дамжин ужгирсан шинжтэй болж байна. Ядууралд орсон хойно түүний эсрэг бодлого явуулахад үр нөлөө нь бага байдаг.

Энэ нь нэгэнт өвчин туссан хойно нь өвчнийг эмчлэхтэй адил бол эмзэг байдлыг тодорхойлж түүний эсрэг бодлого явуулах нь уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаатай адил юм. Өөрөөр хэлбэл, ядууралд орохоос өмнө түүний эсрэг бодлого явуулах нь илүү үр дүнтэй бөгөөд ядуурал нэмэгдэх боломжийг багасгадаг. Тийм учраас ядуурах эмзэг байдал гэдэг нь нийгмийн чухал асуудал юм.

Манай орны хувьд ядуурлыг бууруулах бодлогын хүрээнд эмзэг байдлын асуудал яригдсаар ирсэн. Гэхдээ эмзэг байдлыг эмзэг бүлэг гэсэн ойлголттой холбож ойлгосоор ирсэн. Тухайлбал, өрх толгойлсон эмэгтэй, тахир дутуу хүмүүс гэх мэт бүлгүүдийг эмзэг бүлэг гэж тодорхойлж байсан учраас ядуурлыг бууруулах арга хэмжээг нийгмийн эдгээр бүлгүүдэд илүү чиглүүлж байлаа. Өрхийн эмзэг байдал, нийгмийн эмзэг бүлгүүд гэсэн ойлголтууд нь зарим талаар төсөөтэй боловч ялгаатай гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Бид өрхийн эмзэг байдлыг тодорхойлох загварыг эхлээд авч үзнэ. Дараа нь өрхийн ядуурах эмзэг байдлын эмпирик судалгааг авч үзэх ба эцэст нь судалгаанаас гарах дүгнэлт, зөвлөмжүүдийг тодорхойлох юм.

### **2.2.1 Өрхийн эмзэг байдлыг тодорхойлох загвар**

Өрхийн ядуурах эмзэг байдал гэдэг нь тухайн өрх өнөөдөр ядуу байгаа эсэхээс үл хамааран ирээдүйд ядуурах магадлал юм. Өөрөөр хэлбэл, одоогоор ядуу бус байгаа өрхүүд нь ядуурлын шугамаас доош орох эсвэл одоо ядуу бол цаашид ч ядуу хэвээрээ үлдэх эрсдэлийг эмзэг байдал гэнэ. Ядуурлыг хэмжих нэг түгээмэл арга нь өрхийн нэг хүнд ногдох хэрэглээний зардал юм. Бид ч мөн судалгаандаа өрхийн нэг хүнд ногдох хэрэглээний зардлыг ашиглана. Ядуурлын түвшинг өрхийн тухайн үеийн хэрэглээний зардлаар тодорхойлдог бол ядуурах эмзэг байдлыг ирээдүйн хэрэглээ ядуурлын шугамаас доош орох магадлалаар тодорхойлно. Үүнийг томъёолбол:

$$v_{ht} = \Pr(c_{h,t+1} \leq \underline{c})$$



$c_{h,t}$ -t үеийн h өрхийн хэрэглээ  
 $\underline{c}$ -ядуурлын шугам

Өрхийн ядуурах эмзэг байдлыг тодорхойлохын тулд хэрэглээний функцийг үнэлэх шаардлагатай юм. Өрхийн тэргүүний боловсрол, ажил эрхлэлт, өрхийн ам бүлийн тоо, өрхийн ам бүл дэх тэжээгдэгсдийн хувь гэх мэт үзүүлэлтүүд нь өрхийн хэрэглээнд нөлөөлдөг. Эдгээрээс гадна хэрэглээнд макро эдийн засаг болон нийгэм улс төрийн хүчин зүйлс нөлөөлдөг. Хэрэглээний функцийг дараах байдлаар тодорхойлъё:

$$c_{ht} = c(X_h, \beta_t, \varepsilon_{ht})$$

Үүнд,  $X_h$ -хэрэглээнд нөлөөлдөг хувьсагчид;  $\beta_t$ -t үеийн эдийн засгийн төлөв байдлыг харуулдаг үзүүлэлтүүд;  $\varepsilon_{ht}$ -шокууд.

Өрхийн хэрэглээний зардал болон түүнд нөлөөлдөг хувьсагчдаар хийсэн түүвэр судалгаан дээр үндэслэн хэрэглээний функцийг үнэлж ирээдүйн хэрэглээг тодорхойлж болно.

Хэрэглээний функцийг үнэлэхэд тулгарч болох асуудал нь өрхүүдийн хэрэглээний ялгаатай шинж (heterogeneity) байж болох юм.

Хэрэглээний функцийг үнэлгээгээ ашиглан дараа үеийн хэрэглээг тодорхойлж, уг хэрэглээ нь амьжиргааны доод түвшнээс доогуур болох магадлалыг олсноор өрх бүрийн ядуурах эмзэг байдал гарч ирнэ. (томъёо)

$$v_{ht} = \Pr(c_{h,t+1} = c(X_h, \beta_{t+1}, \varepsilon_{h,t+1}) \leq \underline{c} | X_h, \beta_{t+1}, \varepsilon_{h,t+1})$$

Өрхийн ядуурах эмзэг байдалд дараах хоёр хүчин зүйл нөлөөлж болох юм. Нэгдүгээрт, өрхийн нэг хүнд ногдох дундаж хэрэглээ нь ерөнхийдөө доогуур байдгаас болж тухайн өрхийн ядуурах эмзэг байдал өндөр байна. Хоёрдугаарт, өрхийн нэг хүнд ногдох хэрэглээ нь өөрчлөлт ихтэй байдгаас болж өрхийн ядуурах эмзэг байдал өндөр байна. Хэрэглээний энэ өөрчлөлттэй байдал нь орлого болон бусад үзүүлэлтүүдэд гарах гэнэтийн өөрчлөлтийн үед өрх хэрэглээгээ тогтвортой байлгах чадвартай шууд холбоотой.

Өрхүүдийн ядуурах эмзэг байдал, түүний шалтгаан зэргээс хамаарч бодлого харилцан адилгүй байх ёстой. Тухайлбал, хэрэглээ болон орлого нь маш их өөрчлөгддөгөөс болж ядуурах эмзэг байдал өндөр байвал эмзэг байдлыг бууруулахын тулд өрх гэрүүдэд тулгарч буй эрсдэлийг бууруулах болон эдгээр эрсдэлээс даатгуулах бодлого явуулах хэрэгтэй. Харин тухайн өрх орлого багатайгаасаа болж эмзэг байдалтай байгаа бол төрөөс тусламж, тэтгэмж гэх мэт шилжих төлбөр хийх нь илүү зохистой.

### 2.2.2 Өрхийн ядуурах эмзэг байдлын эмпирик судалгаа

Өрхийн ядуурах эмзэг байдлын эмпирик судалгаанд өрхүүдийн амьжиргааны түвшний динамик үзүүлэлтүүдийг ашиглах нь тохиромжтой.

Гэхдээ ийм үзүүлэлтүүд манай оронд төдийгүй бусад орны хувьд ч ховор байдаг. Бид энэ судалгаандаа өрхийн амьжиргааны нэг удаагийн үзүүлэлтүүдийг ашиглана. Тиймээс өрхийн ядуурах эмзэг байдлын онолын загвараа өгөгдөлдөө тохируулан бага зэрэг өөрчлөө::

$$v_h = \Pr(c_h \leq \underline{c})$$

Энд,  $c_h$  -  $h$  өрхийн хэрэглээ;

$\underline{c}$  - ядуурлын шугам

Ядуурлын шугам нь эдийн засгийн ерөнхий байдал, үнийн түвшинтэй холбоотойгоор өөрчлөгддөг үзүүлэлт. Энэ нь хугацааны тухайн үед хэрэглэгдэж байгаа ядуурлын шугам юм.

Эхлээд хэрэглээний функцийг үнэлгээг авч үзье.

### **Хэрэглээний функцийг үнэлгээ**

Бид хэрэглээ нь дараах хувьсагчдаар тодорхойлогдоно гэж үзсэн. Үүнд өрхийн ам бүлийн тоо, ам бүл дэх тэжээгдэгсдийн эзлэх хувь, өрхийн тэргүүний нас, хүйс, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, ажил эрхлэлт, өрхийн орон байрны нөхцөл, жилийн дундаж орлого, усан хангамж, утас, холбоо ба цахилгаан хангамж гэсэн үзүүлэлтүүдийг хамааруулна.

Benu Bidani ба Kaspar Richter (2001 он) нарын ажилд хэрэглээг дээрх үзүүлэлтүүдээс гадна макро эдийн засгийн үзүүлэлт болон зарим шокуудаас хамааруулжээ. Бидний хувьд зөвхөн 2002 онд явуулсан (cross-section) судалгаан дээр тулгуурлаж байгаа учраас макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг загвартаа оруулах боломжгүй юм.

Үнэлгээ хийхийн тулд бид нэг хүнд ногдох хэрэглээний тархалтыг шалгаж үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэг хүнд ногдох хэрэглээ нь нормал тархалтаар тархдаг үед л бид шугаман хэрэглээний функцийг үнэлэх боломжтой болно. Ингээд шалгаж үзэхэд нэг хүнд ногдох хэрэглээ нь логарифм нормал тархалттай байсан.

Тэгшитгэлд орон нутгийн dummy хувьсагчдыг оруулсан. Учир нь орон нутгийн онцлогтой холбоотойгоор хүмүүсийн хэрэглээ болон түүнд нөлөөлдөг хувьсагчид өөр өөр байх боломжтой. Chow тест хийж үзэхэд орон нутгийн онцлогоос хамаараад хэрэглээнд dummy хувьсагчдыг оруулах хэрэгтэй гэсэн үр дүнд хүрсэн. Chow тестийн үр дүнг хавсралтанд оруулав. Иймээс бидний үнэлэх хэрэглээний функцийг эмпирик загвар дараах хэлбэртэй болсон байна.

$$\begin{aligned} \ln pc = & \alpha_1 + \alpha_2 \ln y + \alpha_3 \ln a + \alpha_4 \ln r + \alpha_5 \ln f + \alpha_6 com + \alpha_7 sex + \alpha_8 mar + \alpha_9 d1 \\ & + \alpha_{10} d2 + \alpha_{11} d3 + \alpha_{12} w1 + \alpha_{13} w2 + \alpha_{14} res1 + \alpha_{15} res2 + \alpha_{16} el + \alpha_{17} e1 + \alpha_{18} e2 + \\ & \alpha_{19} dd1 + \alpha_{20} dd2 + \alpha_{21} dd3 + \alpha_{22} dd4 + \alpha_{23} dd5 \end{aligned} \quad (1)$$

Үүнд,  $\ln y$ -өрхийн жилийн дундаж орлого,  $\ln a$ -өрхийн тэргүүний нас,  $\ln r$ -өрхийн ам бүлд эзлэх тэжээгдэгсдийн хувь,  $\ln f$ -өрхийн ам бүлийн тоо,  $com$ -утаастай

өрхүүдийн dummy хувьсагч, sex-өрхийн тэргүүний хүйс, mar-өрхийн тэргүүний гэрлэлтийн байдал, d1-бага боловсролтой өрхийн тэргүүн, d2-дунд боловсролтой өрхийн тэргүүн, d3-дээд боловсролтой өрхийн тэргүүн, w1-төвийн системийн усан хангамжтай, w2-гүний худгаар усаа хангадаг, res1-орон сууцанд амьдардаг, res2-гэрт амьдардаг, e1-цахилгаан хангамжтай, e1-өрхийн тэргүүн нь төрийн байгууллагад ажилладаг, e2-хувийн секторт ажилладаг, dd1-Архангай аймаг, dd2-Дорноговь аймаг, dd3-Хэнтий аймаг, dd4-Баянзүрх дүүрэг, dd5-Сонгино-Хайрхан дүүрэг.

Ингээд загвараа үнэлж, хэрэглээний шинжийг (White тест) тестэлж үзэхэд бидний урьдчилан таамаглаж байснаар өрхүүд маань хэрэглээний ялгаатай шинжтэй байлаа (Тестийн үр дүнг Хүснэгт1-д харуулсан үед бидний үнэлгээний коэффициентуудын утга зөв байж болох боловч дисперс нь их зөрүүтэй байдаг. Үүнээс болоод бидний “t” статистикийн утга гажилттай байж болно. Ингэснээр энэ нь статистикийн хувьд найдвартай болон найдваргүй хувьсагчдыг ялгахад төвөгтэй байдал бий болгодог. Тухайлбал, уг “t” статистикаар найдвартай хувьсагчид нь найдваргүй мэт харагдаж бид хэрэглээнд нөлөөлдөг хувьсагчдаа регрессээс хасч болзошгүй юм.

Энэ асуудлыг шийдэхийн тулд бид GLS үнэлгээг ашигласан. Өөрөөр хэлбэл, хувьсагч тус бүрээ стандарт алдаанд хуваах замаар шилжүүлж, уг хувьсагчдаар регресс бодсон. Үнэлээд гарсан тэгшитгэлээ Хүснэгт 2-оор харууллаа. Энэ үнэлгээнд CUSUMSQ тест, White тест, RESET тест болон бусад загварын тохиромжтой байдлыг шалгадаг тестүүдийг хийж үзэхэд бүгд найдвартай гарсан.

### Хүснэгт 1. Өрхүүдийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ

	Нийт	хувиар	v>0.3 6	Үүнээс		v>0.5 8	Үүнээс			Үүнээс	
				эмзэг өрхөд	нийт өрхөд		эмзэг өрхөд	нийт өрхөд	v>0.5	эмзэг өрхөд	нийт өрхөд
				эзлэх хувийн жин	эзлэх хувийн жин		эзлэх хувийн жин	эзлэх хувийн жин	эзлэх хувийн жин	эзлэх хувийн жин	эзлэх хувийн жин
нийт	150	100%	98	100	65.333	85	100	56.667	93	100	62
<b>гэрэлсэн</b>	132	88	85	86.735	64.394	73	85.882	55.303	80	86.022	60.606
<b>утагтай</b>	61	40.667	34	87.775	64.179	74	87.059	42.623	32	34.409	52.459
<b>эрэгтэй</b>	134	89.333	86	87.755	64.179	74	87.059	55.224	81	87.097	60.448
<b>эмэгтэй</b>	16	10.667	12	12.245	75	11	12.941	68.75	12	12.903	75
<b>төвийн систем(ус)</b>	22	14.667	10	10.204	45.455	8	9.412	36.364	10	10.753	45.455
<b>гүний худаг</b>	84	56	59	60.204	70.238	52	61.179	61.95	56	60.215	66.667
<b>гол, мөрний ус</b>	44	29.333	29	29.592	65.909	25	29.412	56.818	27	29.032	61.364
<b>орон сууц</b>	20	13.333	9	9.184	45	7	8.235	35	9	9.677	45
<b>хувийн байшин</b>	74	49.33	47	47.959	63.514	40	47.059	54.054	44	47.312	59.459
<b>гэр</b>	56	37.333	42	42.855	75	38	44.706	67.857	40	43.011	71.429
<b>цахилгаантай төрийн байгууллагад хувийн секторт ажилгүй</b>	132	88	83	84.694	62.879	71	83.529	53.788	78	83.871	76.596
бага боловсролтой дунд боловсролтой	47	31.333	37	37.755	78.723	31	36.471	65.957	36	38.71	48.75
дээд боловсролтой	80	53.333	43	43.878	53.75	36	42.353	45	39	41.9355	78.261
ядуу бүлэг	23	15.333	17	18.367	78.261	18	21.176	78.261	18	19.355	85.714
ядуу бус бүлэг	7	4.667	7	7.143	100	6	7.059	85.714	6	6.452	64.762
Архангай	105	70	70	71.429	66.667	63	74.118	60	68	73.118	64.762
Дорноговь	35	23.333	20	20.408	57.143	15	17.647	42.857	18	19.355	51.429
Хэнтий	93	62	93	98.898	100	85	100	91.398	93	100	100
Баянзүрх	57	38	5	5.102	8.772	0	0	0	0	0	0
Сонгино-Хайрхан	38	100	11	100	28.947	7	100	18.421	9	100	23.684
Хан-уул	13	100	10	100	76.923	9	100	69.231	10	100	76.923
	34	100	34	100	100	31	100	91.176	34	100	100
	25	100	15	100	100	15	100	60	15	100	60
	23	100	18	100	100	16	100	69.565	17	100	73.913
	17	100	10	100	100	7	100	41.176	8	100	47.059

**Хүснэгт 2. Жишсэн нэг хүнд ногдох хэрэглээний логарифм функц**

	<i>Коэффициент</i>	<i>t-статистик</i>
<i>Тогтмол</i>	3.0896	12.28527
<i>Орлого (log)</i>	0.7986	57.86477
<i>Өрхийн тэргүүний нас (log)</i>	-0.1605	-4.953993
<i>Өрхийн тэжээгдэгсдийн хувь (log)</i>	-0.074	-2.687458
<i>өрхийн ам бүлийн тоо (log)</i>	-0.756	-26.93236
<i>Утас, холбоо</i>	0.0745	2.24747
<i>Өрхийн тэргүүний боловсрол</i>	0.119	2.879742
<i>Дунд (dummy)</i>		
<i>Өрхийн тэргүүний боловсрол: дээд (dummy)</i>	0.127	2.911504
<i>Орон байр: гэр (dummy)</i>	0.191	8.257932
<i>Цахилгаан хангамж (dummy)</i>	-0.056	-4.651414
<i>Өрхийн тэргүүний ажил эрхлэлт: төрийн байгууллага (dummy)</i>	-0.149	-7.7441
<i>Орон нутаг: Архангай (dummy)</i>	0.766	34.24154
<i>Орон нутаг: Дорноговь (dummy)</i>	0.404	6.307935
<i>Орон нутаг: Сонгино-Хайрхан дүүрэг (dummy)</i>	0.173	3.171747
$R^2$	0.99	
DW	1.8	

Үнэлгээний үр дүнгээс харвал өрхийн нэг хүнд ногдох хэрэглээнд нөлөөлдөг чухал хүчин зүйл нь өрхийн орлого болж байна. Тухайлбал, хэрэглээний орлогоос хамаарсан мэдрэмж 0.799 буюу орлого 1 хувь өсөхөд хэрэглээ 0.799 хувиар өснө гэсэн үг. Энэ нь онолын таамаглал болоод бусад судлаачдын ажилтай таарч байна. Мөн өрхийн тэжээгдэгсдийн ам бүлд эзлэх хувь нь хэрэглээнд сөрөг нөлөөтэй байна. Жишээ нь, өрхийн тэжээгсдийн ам бүлд эзлэх хувь 1 хувиар өсвөл нэг хүнд ногдох хэрэглээ нь 0.07 хувиар буурч байна. Мөн түүнчлэн өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам нэг хүнд ногдох хэрэглээ (-0.756) буурна.

Боловсрол нь өрхийн нэг хүнд ногдох хэрэглээнд эерэг нөлөөтэй бөгөөд боловсролын түвшингийн нөлөөллийн зэрэг нь харилцан адилгүй байна. Тухайлбал, дээд боловсрол нь дунд боловсролыг бодвол хэрэглээнд илүү нөлөөтэй байна. Орон сууц эсвэл хувийн байшинд амьдардаг өрхүүд, болон өрхийн тэргүүн нь төрийн байгууллагад ажилладаг бол тухайн өрх харьцангуй бага хэрэглээтэй байна. Утастай өрхийн хэрэглээ нь утасгүй өрхүүдийг бодвол бага зэрэг өндөр (0.0745). Архангай (0.766), Дорноговь (0.404) болон Сонгино-Хайрхан дүүрэг (0.173)-ийн хэрэглээ арай өндөр байна.

### Эмзэг байдлын үнэлгээ

Үнэлсэн хэрэглээний функцээ ашиглан өрх бүрийн эмзэг байдлыг дараах байдлаар тооцож олъё:


$$v_h = \Pr(c_{h,t+1} \leq \underline{c}) = \Phi\left(\frac{\ln \underline{c} - \hat{\beta}X_h}{\hat{\sigma}}\right)$$

Энд:  $\Phi$  нь стандарт нормаль тархалтын функц. Учир нь бид хэрэглээний логарифм нь  $\hat{\beta}X_h$  дундажтай,  $\hat{\sigma}$  дисперстэйгээр нормаль тархдаг гэж үзсэн. Үүнээс гадна бидний шийдэх ёстой нэг асуудал бол ядуурах эмзэг байдлын босго үзүүлэлтийг сонгох явдал юм. Өрхийн ядуурах эмзэг байдлын босго үзүүлэлтийг 3 янзаар сонгосон. Үүнд нэгдүгээрт, босго үзүүлэлтийг 0.36-аар сонгосон. Учир нь 1995, 1998 оны Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгаанаас Монголын нийт өрхийн 36 орчим хувь ядуу гэсэн үр дүн гарсан. Эндээс бид Монголын хувьд өрхийн ядуурах эмзэг байдлын дундаж үзүүлэлт нь 0.36 гэж үзээд үүнийг босго үзүүлэлтээр сонгосон.

Хоёрдугаарт, магадлалын дундаж үзүүлэлт, мөн түүнчлэн ядуурах магадлал өндөр болж байгаа гэдэг үүднээс 0.5-ийг босго үзүүлэлтээр сонгосон. Гуравдугаарт, бидний авсан түүврийн ядуурлын түвшин 58 хувь учраас 0.58-ийг босго үзүүлэлт болгон авсан. Дөрөвдүгээрт, босго үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд ядуурах эмзэг байдлын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харах үүднээс 0.7 гэсэн босго үзүүлэлтийг сонгож үзье.

Босго үзүүлэлт өндөр болох тутам эмзэг өрхийн тоо буурах хандлагатай байсан. Босго үзүүлэлтийг 0.36-аар сонгож авахад 98 өрх буюу түүвэрт хамрагдсан өрхийн ядуурах эмзэг байдал нь 66 хувь байна. Эдгээрээс 93 өрхийн дундаж хэрэглээ нь амьжиргааны доод түвшингээс бага байгаагаас болж эмзэг байдалтай байна. Харин үлдсэн 6 өрхийн хувьд хэрэглээний их өөрчлөгдөмтгий байдлаас болж ядуурах эмзэг байдалд байна гэж дүгнэж болно. Босго үзүүлэлт өссөнөөр хэрэглээ нь их хэлбэлздэг бүлгийн эмзэг байдалд хамрагдалт нь буурсан.

Харин эмзэг байдал нь 0.5-аас дээш 93 өрх, 0.7-оос дээш 77 өрх байсан. Энэ үед ядуурах эмзэг байдлын шалтгаан нь тухайн өрхүүдийн дундаж хэрэглээ маш бага байсан явдал юм.



Өрхийн тэргүүний боловсролын түвшин дээшлэх тусам эмзэг байдал буурч байна. Нийт түүврийн хэмжээнд өрхийн тэргүүн нь төрийн байгууллагад ажилладаг эсвэл ажилгүй бол тухайн өрх эмзэг байна. Үүнээс гадна орон сууц болон хувийн байшинд амьдардаг өрхүүдээс гэрт амьдардаг өрхүүд нь эмзэг бүлэгт илүү хамрагдаж байна.

Орон нутгуудаар авч үзвэл Хэнтий аймгийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн ядуурах эмзэг байдал хамгийн өндөр байна. Архангай аймагт ядуурах эмзэг байдал харьцангуй бага байлаа.

Ядуу болон ядуу бус өрхүүдээс орлогын таван бүлэгт хувааж бүлэг тус бүрийн эмзэг байдлыг тодорхойлсон. Үүнийг Хүснэгт 6-д харууллаа. Нэн ядуу буюу нэг хүнд ногдох сарын дундаж орлого нь 0-7640 төгрөг байдаг өрхүүд бүгд эмзэг байдалтай байна. Харин орлого өсөх тусам өрхүүдийн эмзэг байдал буурч байсан. Нэг хүнд ногдох сарын дундаж орлого 50000 ба түүнээс дээш болоход эмзэг өрхүүд байсангүй.

### **Бодлогын нөлөөллийн шинжилгээ**

Ажил эрхлэлтийг бий болгох бодлого явуулснаар өрх бүрийн тэжээгдэгсдийн хувь 10 хувиар буурсан гэж үзвэл эмзэг байдалд ямар нөлөө үзүүлэхийг тооцож үзье. Ингэхэд эмзэг байдал нь 0.36 болон 0.5-аас дээш өрхийн тоо тус бүр 2-оор, 0.7-оос дээш эмзэг байдалтай өрхийн тоо 3-аар буурч байна. Эндээс үзвэл ажил эрхлэлт нь өрхүүдийн ядуурах эмзэг байдалд ихээхэн нөлөөтэй байна.

### Хүснэгт 3. Өрхийн нэг хүнд ногдох орлого ба өрхийн ядуурах эмзэг байдлын хамаарал

нэг хүнд ноогдох орлогыг интервалд хуваавал	Үүнээс								
	интервалд хамаарах өрхийн тоо	эмзэг байдал нь 0.36-аас дээш өрхийн			эмзэг байдал нь 0.5-аас дээш өрхийн			эмзэг байдал нь 0.5-аас дээш өрхийн	
		тоо	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
1 0-7640	24	24	100	24	100	22	91.66		
2 7640-19100	63	49	77.77	47	74.60	43	68.25		
3 19100-30000	36	23	63.88	21	58.33	12	33.33		
4 30000-50000	15	2	13.33	1	6.667	0	0		
5 50000 -аас дээш	12	0	0	0	0	0	0		

Мөн төрийн албан хаагчдын цалинг 20 хувь нэмсэн гэж үзье. Ингэхэд 0.36-аас дээш эмзэг байдалтай өрхийн тоо 26 хувиар (40 хувь хүртэл) буурсан. Харин 0.5-аас дээшхи эмзэг байдалтай өрхийн тоо 24 хувиар (48 хувь хүртэл) 0.7-оос дээш их эмзэг байдалтай өрхийн тоо 18 хувиар (35.33 хувь болтол) буурчээ. Эндээс үзвэл төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх бодлого нь өрхийн эмзэг байдлыг бууруулахад ихээхэн нөлөөлсөн байж болох юм.

### ДҮГНЭЛТ

Энэ судалгаа нь Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлыг үнэлэх зорилготой юм. Ядуурах эмзэг байдлын судалгааг олон улсын хэмжээнд өргөнөөр хийж байна. Тухайлбал, Филиппин, Тайланд, Турк гэх мэт олон оронд хийгдсэн. Харин манай орны хувьд эмзэг байдлыг эмзэг бүлэг гэсэн явцуу хүрээнд ойлгож ирсэн бөгөөд ядуурах эмзэг байдлын судалгаа урьд өмнө нь огт хийгдэж байгаагүй юм.

Энэ судалгаа нь ядуурах эмзэг байдлын судалгааг Монголд анх удаа Монголын өрхүүдийн хувьд хийж, ядуурах эмзэг байдлын ойлголтыг оруулж ирж байгаагаараа онцлог юм.

#### 1.Эмпирик судалгааны үр дүн

Өрхийн ядуурах эмзэг байдлын судалгааг Улаанбаатар хот, Дорноговь, Архангай болон Хэнтий аймгийн 150 өрхийн үзүүлэлтүүдийг ашиглан хийж, дараах дүгнэлтэнд хүрсэн. Судалгаа нь өрхийн хэрэглээний функцийг үнэлгээ болон өрхийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ хийх гэсэн хоёр үе шаттай байлаа. Эмпирик судалгааны үр дүнгээс харвал, өрхийн нэг хүнд ногдох хэрэглээнд өрхийн орлого, ам бүлд эзлэх тэжээгдэгсдийн хувь, ам бүл, орон байрны нөхцөл, ус, цахилгаан хангамж, утас, өрхийн тэргүүний нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Бидний үнэлгээнээс үзвэл нэг хүнд ногдох хэрэглээ нь орон нутгийн онцлогоос хамааран өөрчлөгдөж байна. Тухайлбал, нэг хүнд ногдох хэрэглээ Архангай, Дорноговь аймаг болон Сонгино-Хайрхан дүүрэгт харьцангуй өндөр байна.



2002 онд бидний авсан түүвэр судалгааны өгөгдлийг ашиглан өрхүүдийн ядуурах эмзэг байдлыг судлах шинэ аргалчлалыг практикт хэрэглэсэн.

Бидний сонгосон түүврийн хувьд ядуурах эмзэг байдлын босго үзүүлэлтийг хэрхэн авснаас хамааран эмзэг байдлын түвшин өөр өөр байна. Босго үзүүлэлт 0.36 үед 65 хувь, 0.5 үед 62 хувь 0.7 үед 51 хувь тус тус байна. Эндээс үзвэл босго үзүүлэлтээс ядуурах эмзэг байдлын түвшин урвуу хамаарч байна. Өрхүүдийн ядуурах эмзэг байдлын дундаж утга 0.36 байхад эмзэг байдлын түвшин 65 хувь гэдэг нь нийт өрхүүдийн 65 хувь нь дунджаас дээш ядуурах эрсдэлтэй байна гэсэн үг юм. Эмзэг байдлын түвшин орлогын бүлэг тус бүрд харилцан адилгүй байна. Ядуу өрхүүдийн эмзэг байдлын түвшин нь ядуу биш өрхүүдийн эмзэг байдлын түвшингээс 91 хувиар өндөр байна.

Боловсролын түвшин ахихын хирээр өрхүүдийн ядуурах эмзэг байдлын түвшин буурч байна. Орон байрны нөхцөлөөр нь авч үзвэл гэрт амьдардаг өрхүүдийн ядуурах эрсдэл хамгийн өндөр байхад орон сууцанд амьдардаг өрхүүдийнх хамгийн бага байна. Мөн эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн эмзэг байдлын түвшин эрэгтэй тэргүүнтэй өрхүүдийнхээс 10.1 хувиар өндөр байна. Хувийн сектор ажилладаг тэргүүнтэй өрхүүдийн эмзэг байдлын түвшин төрийн байгууллагад ажилладаг тэргүүнтэй өрхүүдийнхээс 25 хувиар өндөр байна.

Орон нутгаар нь авч үзвэл Хэнтий, Дорноговь аймаг Сонгино-Хайрхан дүүрэгт ядуурах эмзэг байдал түүврийн дунджаас өндөр байна. Харин Архангай аймагт ядуурах эмзэг байдлын түвшин түүврийн дунджаас бага байна.

Сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, зуданд Монголын нэлээд олон тооны малчид нэрвэгдэж улмаар энэ нь эдийн засгийн өсөлт, ядуурал, ядуурлын тархалтанд нөлөөлсөн гэж судлаачид ярьсаар ирсэн. Бид энэ нөлөөллийг загвартаа оруулах гэсэн боловч судалгаа авсан нийт орон нутаг бүгд зуданд хамрагдсан байснаас боломжгүй болсон.

Цаашид олон жилийн үзүүлэлтүүдийг нийт орон нутгийг хамруулан авсан тохиолдолд ядуурах эмзэг байдалд зуд хэрхэн нөлөөлж байгааг судлах боломжтой.

## **2.Бодлогын саналууд**

Ядуурлыг бууруулах явдал нь манай Засгийн Газрын хамгийн чухал эн тэргүүний зорилго юм. Монголын ядуурлыг бууруулах бодлого нь ядуу өрхийг ядуурлаас гаргах болон ядуурч болзошгүй өрхүүдийг ядуурахаас урьдчилан сэргийлэх бодлогоос бүрдэх ёстой. Энэ хоёр бодлого нь зарчмын хувьд өөр төдийгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь харилцан адилгүй юм.

Бидний хийсэн судалгаанаас үзвэл боловсролын түвшинг сайжруулах бодлого нь өрхийн ядуурах эмзэг байдлыг бууруулахад нэн чухал ач холбогдолтой байна.

Ядуурахаас урьдчилан сэргийлэх бодлогыг бүс нутагт харилцан адилгүй явуулах шаардлагатай байна. Засгийн Газраас аймаг, бүс нутагт ядуурлыг бууруулахад зарцуулах хөрөнгө, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг аймаг бүс нутаг, нийгмийн бүлэг давхарга тус бүрээр ялгаатай явуулснаар ядуурлыг бууруулах зорилгоо амжилттай хэрэгжүүлэх боломжтой. Бидний хийсэн тандах судалгааны үр дүнгээс харвал Архангай аймагт эмзэг байдлын түвшин хамгийн бага байхад, Хэнтий аймагт хамгийн өндөр байна. Судалгаанаас үзвэл ядуу биш өрхүүдийн ядуурах эмзэг байдлын түвшин 8.8 хувь байгаа нь ядуурахаас урьдчилан сэргийлэх бодлогыг ядуу төдийгүй ядуу биш өрхүүдийн эмзэг хэсэгт чиглүүлэх шаардлагатай байна.

Хэдийгээр энэ судалгаа Монголын өрхүүдийг хамарсан дүгнэлт хийх боломжгүй ч сонгосон түүврийн хувьд нэн сонирхолтой үр дүн гарсан нь цаашид энэ чиглэлийн ултай судалгаа хийх шаардлагатай болохыг харуулж байна. Түүврийг Монголын нийт өрхийг төлөөлөхүйц болгож чадсан тохиолдолд уг судалгааны аргыг ашиглан ядуурах эмзэг байдлыг бууруулах буюу ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлогын зөвлөмжийг боловсруулах боломжтой.

### **3.Цаашид хийгдэж болох судалгааны чиглэлүүд**

Цаашид энэ судалгааг Монголын нийт өрхийн төлөөлөлтэй түүвэр судалгааны үзүүлэлтүүдийг ашиглан хийх нь зүйтэй бөгөөд ингэснээр бодлого боловсруулалтанд хэрэгтэй мэдээллийг бий болгоно. Тухайлбал, 1998 оны Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгааны өгөгдлүүдийг ашиглан хийж болно. Энэ судалгааг динамик өгөгдөл ашиглан хийх нь илүү тохиромжтой гэж дээр дурдсан. Энэ онд ҮСГ-аас Дэлхийн Банкны дэмжлэгтэй хийж буй Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгааны өгөгдлүүдийг 1998 оныхтой хамт үнэлгээнд ашиглавал маш сонирхолтой шинжилгээнүүдийг хийж, макро эдийн засгийн, цаг агаарын өөрчлөлт зэргийн нөлөөллийг харах боломжтой байж болно.

Бидний хийсэн судалгааны үр дүнг олон улсын судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулж үзэхэд ерөнхий хандлага, онолын дүгнэлтүүд нийцтэй байна. Эндээс бид өрхийн ядуурах эмзэг байдлыг тодорхойлох энэ аргачлал нь Монголын эдийн засагт хэрэглэх боломжтой гэж дүгнэж байна.

Цаашид энэ аргачлалаар Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгааг үндэсний хэмжээгээр хийх боломжтой бөгөөд ийм судалгаа ядуурлыг бууруулах бодлого боловсруулахад зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

### **НОМ ЗҮЙ:**

1. Benu Bidani, Kaspar Richter "Household Vulnerability and The Asian Crisis: The Case of Thailand" June 2001
2. Robert Holzmann "Risk and Vulnerability: The Forward Looking of Social Protection in a Globalizing World " February 2001, Social Protection Workshop

3. Shubham Chaudhuri "Empirical methods for assessing household vulnerability to poverty" March 2000
4. Shubham Chaudhuri, Gaurav Datt "Assessing household vulnerability to poverty: a methodology and estimates for the Philippines" March 2001, Vulnerability Workshop at the World Bank, Washington D. C.
5. Shubham Chaudhuri "Reconceptualizing poverty assessments to take account of vulnerability" June 2001, Workshop on poverty and vulnerability Third Asia Development Forum Bangkok
6. Binayak Sen "Risks, Vulnerability and Poverty in Bangladesh: Issues and Evidence (Variations on a Theme)" September 2001, Bangladesh Institute of Development Studies.
7. The World Bank Group "Poverty Trends and Voices of the Poor: Prospects for poverty reduction" August 2002
8. Christopher B. Barrett "On Vulnerability, Asset Poverty and Subsidiarity" May 1999, New York City
9. Economic and Social Commission for Asia and the Pacific "Vulnerability and Poverty in Asia and the Pacific a Conceptual Note" June 2001
10. David Hulme, Andrew Shepherd and Karen Moore "Chronic Poverty: Meanings and Analytical Frameworks"
11. "Risks and Vulnerability Profiles" 2001
12. Ruslan Yemtsov "Living Standards and Economic Vulnerability in Turkey between 1987 and 1994" January 2001
13. World Bank "Risks, Poverty, and Insurance: Innovations for the Informal Economy /Workshop Proceedings Summary /" September 2000
14. Suvit Yodmani "Disaster Risk Management and Vulnerability Reduction: Protecting the Poor" February 2001, Social Protection Workshop
15. Suvit Yodmani "Chapter-13-Disaster Preparedness and Management"
16. Charlotte Benson and Edward J. Clay "Disasters, Vulnerability and the Global Economy" 1998
17. Asian Development Bank, Asian Development Bank Institute, Economic and Social Commission for Asia and the Pacific, The World Bank" Vulnerability and Poverty in Asia and the Pacific a Conceptual Note" June 2001, Bangkok
18. World Development Report 2000/2001, Attacking poverty, 2001. Oxford University Press
19. Government Programme 'Good Governance For Human Security' "National Workshop Integrating Poverty Reduction Into Development Strategy" vol.1 september 2001 Ulaanbaatar
20. Government Programme 'Good Governance For Human Security' "National Workshop Integrating Poverty Reduction Into Development Strategy" vol.2 september 2001 Ulaanbaatar
21. МУИС-н эдийн засгийн сургууль, ЕХ/ТАСИС хөтөлбөр, Манчестерийн их сургууль "Монголын Эдийн Засаг шилжилтийн эдийн засгийн гарын авлага" 1999
22. УСТ." Хүн амын амьжиргааны доод түвшинг батлах тухай тушаал" 2002.07.18 №123. Улаанбаатар

23. ҮСГ, НҮБХХ “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1995, 1998” 1999, 8-р сар  
Улаанбаатар
24. ЭМНХЯ, UNICEF, НЭМХ-ХСТ “Хүн амын хоол тэжээлийн байдал /Үндэсний хоёр  
удаагийн судалгаа/”2000 он, Улаанбаатар
25. ҮСГ, Дэлхийн банк “Монгол улс Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх  
судалгаа 2000” 2001, Улаанбаатар хэвлэлийн “Адмон” компани
26. Дэлхийн банк “Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг” 2001,  
Улаанбаатар
27. Монгол Улсын Засгийн Газар “Ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөр /төгсгөлийн  
хураангуй тайлан 1994-2000/” 2001, Улаанбаатар хэвлэлийн “Адмон” компани
28. Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ “Монголын хүний хөгжлийн илтгэл 2000” 2000,  
Улаанбаатар хэвлэлийн “Адмон” компани
29. Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургууль: Эдийн Засгийн Онолын  
Тэнхим “Эдийн Засгийн Онолын Эрдэм шинжилгээний цуврал бичиг №5 ” 2000,  
Улаанбаатар